

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2024/15/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5-9
3. Аудитын илрүүлэлт	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.12 № 281

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Б.ЭНХБААТАР ТАНАА

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011021144

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилгах хөрөнгө	1,638,793.00	11,891,454.00
2	Авлага	8,572,000.00	4,000,000.00
3	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,210,793.00	15,891,454.00
4	Машин тоног төхөөрөмж	3,450,000.00	10,804,000.00
5	Хуримтлагдсан элэгдэл	(2,760,000.00)	(2,786,093.00)
6	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	690,000.00	8,017,907.00
7	Нийт хөрөнгийн дүн	10,900,793.00	23,909,361.00
8	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	10,900,793.00	23,909,361.00
9	Өр төлбөр	120,000.00	152,000.00
10	Татварын өглөг	120,000.00	152,000.00
11	Хуримтлагдсан үр дүн	10,780,793.00	23,757,361.00
12	Өмнөх үеийн үр дүн	20,666,996.00	10,780,793.00
13	Тайлант үеийн үр дүн	(9,886,203.00)	12,976,568.00
14	Эздийн өмчийн дүн	10,780,793.00	23,757,361.00
15	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10,900,793.00	23,909,361.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,488,497.00	42,017,419.00
1.1	Борлуулалтын орлого	1,488,497.00	42,017,419.00
2	Нийт зардал	11,374,700.00	29,040,851.00
2.1	Ерөнхий ба удирдлагын зардал	11,374,700.00	29,040,851.00
2.2	Татварын дараах ашиг (алдагдал)	(9,886,203.00)	12,976,568.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(9,886,203.00)	12,976,568.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,488,497.00	46,589,419.00
2	Буцаан авсан албан татвар	-	4,572,000.00
3	Татаас санхүүжилтийн орлого	-	25,238,973.00
4	Бусад мөнгөн орлого	1,488,497.00	16,778,446.00

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	Мөнгөн зарлагын дүн	19,136,700.00	29,008,852.00
6	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	4,410,000.00	10,908,000.00
7	Ашиглалтын зардал		4,101,000.00
8	Шатахууны зардал		1,997,556.00
9	Томилолтын зардал		2,029,500.00
10	Татварын байгууллагад төлсөн	370,000.00	1,180,000.00
11	Даатгалын төлбөрт		750,612.00
12	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	14,356,700.00	8,042,184.00
13	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(17,648,203.00)	17,580,567.00
14	Хөрөнгийн зарлагын дүн	-	7,327,813.00
15	Тоног төхөөрөмж		7,327,813.00
16	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(17,648,203.00)	10,252,661.00
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,286,996.00	1,638,793.00
18	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,638,793.00	11,891,454.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	10,780,793.00	10,780,793.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын нөлөө алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант оны цэвэр ашиг/алдагдал/	-	-	12,976,568.00	12,976,568.00
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-	23,757,361.00	23,757,361.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	2023 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Урамшуулал	11,280,000.0	11,280,000.0	-	100%
2	Гэрээт нягтлан бодогчийн хөлс	840,000.0	840,000.0	-	100%
3	Нийгмийн даатгал, татвар	1,393,800.0	1,930,612.0	(536,812.00)	139%
4	Албан томилолт	2,056,000.0	2,029,500.0	26,500.00	99%
5	Тээвэр шатахуун	1,732,500.0	1,997,556.0	(265,056.00)	115%
6	Харилцаа холбоо	480,000.0	479,389.9	610.15	100%
7	Сургалт, сурталчилгаа	1,000,000.0	937,653.0	62,347.00	94%
8	Бичиг хэрэг	350,000.0	567,200.0	(217,200.00)	162%
9	Банк шимтгэл	30,000.0	52,600.0	(22,600.00)	175%
10	Хөрөнгө оруулалт	7,500,000.0	7,394,800.0	105,200.00	99%
11	Бусад зардал		360,000.0	(360,000.00)	
	ДҮН	26,662,300.0	27,869,310.9	(1,207,010.85)	105%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.